



# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

Чингис хот  
2020 он

Төрийн албаны тусгай шалгалт, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах шалгалтын талаар:

**Төрийн албаны тусгай шалгалт, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах шалгалтын зарыг шалгалтын бүртгэл эхлэхээс ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар олон нийтэд хүргэнэ.**

**Бүртгэлийг ажлын 1 өдөрт багтаан 09:00-17:00 цагийн хооронд Салбар зөвлөл цахимаар хүлээн авна. 17:00 цагт бүртгэл хаагдах тул бүртгэл хаагдсанаас хойш баримт бичиг илгээх, хүлээн авах боломжгүй. /материалыг PDF файлаар ирүүлнэ./**

Төрийн албаны тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэг, дүн шилжилгээ хийх чадвар, асуудал шийдвэрлэх чадвар, монгол хэлний ярианы болон бичгийн чадварын шалгалтыг сорил хэлбэрээр дараах хялбаршуулсан горимоор авна.

- \* Хууль, эрх зүйн мэдлэгийн шалгалтын агуулга 15 сорилтой, үргэлжлэх хугацаа 15 минут
- \* Дүн шилжилгээ хийх чадварын шалгалтын агуулга 10 сорилтой, үргэлжлэх хугацаа 10 минут
- \* Асуудал шийдвэрлэх чадварын шалгалтын агуулга 10 сорилтой, үргэлжлэх хугацаа 10 минут
- \* Монгол хэлний ярианы болон бичгийн чадварын шалгалтын агуулга 10 сорилтой, үргэлжлэх хугацаа 10 минут
- \* Сорилын хариултын оноо тус бүрийг 2-оор үржигдэн шалгалтын дүнгийн хуудсанд тавигдана.

Төрийн албаны удирдан зохион байгуулах, манлайлах, багаар ажиллах чадварын шалгалтыг ярилцлагын хэлбэрээр авах бөгөөд шалгалт тус бүр 1 асуулттай, үргэлжлэх хугацаа тус бүр 3 минутаас илүүгүй байна.

Төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэдээс төрийн захиргааны туслах түшмэлийн албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалтыг зөвхөн тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэг, монгол хэлний ярианы болон бичгийн чадварын шалгалтаар дараах тусгайлсан гоимоор авна.

- Тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэгийн шалгалтын агуулга 15 сорилтой, үргэлжлэх хугацаа 15 минутаас илүүгүй,
- Монгол хэлний ярианы болон бичгийн чадварын шалгалтын агуулга 15 сорилтой, үргэлжлэх хугацаа 15 минутаас илүүгүй,

## ТӨРИЙН АЛБАНЫ ТУСГАЙ /ТУХАЙН АЛБАН ТУШААЛЫН/ ШАЛГАЛТАД ОРОЛЦОХ ИРГЭНИЙ БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- \* Төрийн албан хаагчийн анкет /“А”, “Б” хэсэг/;
- \* Тусгай шалгалтад бүртгүүлэх тухай бичгээр гаргасан хүсэлт;
- \* Иргэний үнэмлэх;
- \* Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах/;
- \* Нийгмийн даатгалын дэвтэр зэрэг хөдөлмөр эрхлэлтийн байдлыг нотлох баримт;
- \* “4 х 6” см хэмжээтэй цээж зураг;
- \* Шаардлагатай бол мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт;
- \* Төрийн албан хаагчийн хувьд үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн сүүлийн гурван удаагийн үнэлгээний баримт;
- \* Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд холбогдох нотлох баримт;

## Тайлбар:

- \* Дээр дурдсан баримт бичгийг нотариатаар баталгаажуулсан байхыг заавал шаардахгүй бөгөөд **баримт бичгийн үнэн зөвийг иргэн хариуцна.**
- \* Хэрвээ хуурамч баримт бичиг бүрдүүлэн төрийн албаны тусгай шалгалтад бүртгүүлсэн, оролцсон, нэр дэвшсэн, албан тушаалд томилогдсон нөхцөлд үүнээс үүдэн гарах **хариуцлагыг буруутай этгээд хүлээнэ.**
- \* Баримт бичгийн эх хувийг зохих шаардлагад нийцүүлэн **цахим хэлбэрээр, тогтоосон хугацаанд** хүргүүлнэ.
- \* Төрийн албан хаагчийн анкет, шалгалтад бүртгүүлэх тухай хүсэлтэд **өөрийн гарын үсгээ** зурсан байна.